

ТӨРИЙН ЦЭРГИЙН БОЛОН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ТУСГАЙ АЖИЛЛАГААНЫ ХҮЧНИЙ (SOF, SWAT) ЭКСТРЕМИЗМ, РАДИКАЛЧЛАЛД ӨРТӨМТГИЙ БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА

A STUDY ON THE VULNERABILITY OF SPECIAL OPERATIONS FORCES (SOF, SWAT) OF STATE MILITARY AND LAW ENFORCEMENT AGENCIES TO EXTREMISM AND RADICALIZATION

Х.Булгантамир
Судлаач

Товч агуулга: Барууны улсуудын цэргийн тусгай ажиллагааны хүчин (цаашид “SOF” гэх), хууль сахиулах албаны тусгай бэлтгэлтэй мэргэшсэн тактикийн нэгж (цаашид “SWAT” гэх)-ийн алба хаагчид хэт барууны экстремист, радикалчлалд өртөх байдал, түүнд нөлөөлж болзошгүй хүчин зүйлийг талаар судалсан. Ингэхдээ ХБНГУ, Канад, Австрали, АНУ зэрэг улсын 6 элит нэгжийн хууль бус үйлдэл, ёс суртахууны зөрчлийн талаар мөрдөн шалгах ажиллагаа явуулсан ажлын хэсгийн тайланд үндэслэн үндэс угсаа, хүйсийн ялгаатай байдал, элит дайчдын бусдаас өөр байх, ялгарах, хаалттай байдлын онцлог, өөрийн үзэл бодол, итгэл үнэмшлийг зөв гэж үзэх нь хэт барууны экстремизм, радикалчлалд өртөгдөх хүчин зүйл болж болзошгүй талаар дурдсан. Мөн төрийн цэргийн байгууллагуудын тусгай хүчин болон хууль сахиулах албаны SWAT багууд ийм төрлийн үйл ажиллагаанаас ангид байх, урьдчилан сэргийлэх шаардлагатай болохыг онцолсон.

Abstract: The study examined the vulnerability of military special operations forces (hereinafter referred to as “SOF”) and law enforcement special operations tactical units (hereinafter referred to as “SWAT”) of Western countries to far-right extremism and radicalization, and the factors that may influence it. Based on the report of a working group that investigated the illegal actions and moral violations of six elite units in Germany, Canada, Australia, and the United States, it was noted that ethnic and gender differences, the characteristics of elite fighters being different from others, distinguishing themselves, and being closed, and considering one’s own views and beliefs as correct, may be factors that may contribute to far-right extremism and radicalization. It also emphasized the need for special forces of state military organizations and SWAT teams of law enforcement agencies to be free from and prevent such activities.

Түлхүүр үг: Тусгай ажиллагааны хүчин, тусгай зэвсэг, тактик, цэрэг, хууль сахиулах үйл ажиллагаа, экстремист радикал үзэл, эмзэг байдал, эрсдэлийн хүчин зүйл.

Keywords: Special operations forces, special weapons, tactics, military, law enforcement, extremist radicalism, vulnerability, risk factors.

Удиртгал

2020 оны сонгуулийн үр дүнг эсэргүүцэж АНУ-ын нийслэл Вашингтон хот дахь Конгрессын барилга Капитол руу 2021 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр АНУ-ын тухайн үеийн ерөнхийлөгчийг дэмжигчид халдсаны дараа хууль сахиулах байгууллага болон цэргийн алба хаагчдыг экстремизм, радикалчлалд өртөх, учирч болзошгүй аюул, хор уршигт анхаарал хандуулах болсон. Зөвхөн АНУ-д төдийгүй барууны орнуудад хэт туйлширсан, барууны үзэл санааг тээгч иргэд, бүлэглэлүүдийг дэмжиж буйгаа илэрхийлсэн цагдаа, цэргийн алба хаагчдын талаар нийтийн сүлжээгээр олон нийтэд тархсанаар, энэ асуудлыг судлах ажил улсуудад эрчимжсэн.

АНУ-д цэргийн алба хаасан, хэт туйлшрах үзэлтнүүдийн талаарх мэдээллээс харахад, 2010 оноос хойших 10 жилд идэвхтэй алба хааж буй цэргүүд холбогдсон тохиолдлууд мэдэгдэхүйц өссөн. 2021 онд хамгийн их өсөлттэй хэмжээнд хүрсэн байна.² Мөн Женсен (Jensen) болон бусад судлаачдын тэмдэглэснээр,³ хэт туйлширсан үзэлтэй холбоотой тархалт, гэмт хэргүүд зэвсэгт хүчний анги салбаруудад харилцан адилгүй гарсан бөгөөд АНУ-ын арми, тэнгисийн явган цэрэгт хамгийн өндөр хувийг эзэлсэн. 1990-2021 оны хооронд эдгээр хоёр салбар нийт тохиолдлуудын 68 хувийг эзэлсэн.⁴ Нийтэд нь авч үзвэл, тэнгисийн хүчин болон агаарын хүчнүүд харьцангуй бага үзүүлэлттэй байсан. Тэнгисийн явган цэрэг (Marine Corps) нь Тэнгисийн хүчин, Агаарын хүчний бие бүрэлдэхүүнээс бага бүрэлдэхүүнтэй боловч экстремист гэмт хэрэгт холбогдох тохиолдол хамгийн өндөр байна.⁵ Энэ бүгдээс харахад цэргийн болон хууль сахиулах байгууллагууд, тэдгээрийн харьяа нэгжүүдийн алба хаагчид хэт туйлшрах үзэлд автахад тал бүрийн хүчин зүйлсийн нөлөөгөөр ижил бус байдлаар өртөж болзошгүй. Хэдийгээр ялгаатай, өөр хоорондоо харилцан адилгүй кейс тохиолдлуудыг эс тооцвол цэрэг, цагдаагийн алба хаагчид руу чиглэсэн ерөнхий чиг хандлагаас давахуйц судалгааны ахиц дэвшил гараагүй байна.⁶

Энэхүү сэдэв нь учирч болзошгүй хор уршиг, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн талаар судалж, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын тусгай ажиллагааны хүчнүүд SOF, тусгай бэлтгэлтэй мэргэшсэн нэгж S.W.A.T-ийн алба хаагчдын дунд хэт туйлширсан үзэлд өртөгдөх хүчин зүйлсийг судалсан. Эдгээр нэгжүүдийн алба хаагчдыг экстремист радикалчилалд өртөх магадлал бага, сөрөн тэсвэрлэх чадвартай гэж үзэж болох юм. Учир нь, алба хаагчдыг сонгон шалгаруулах үйл явц нь хатуу чанга, илүү хариуцлагатай, өндөр үзүүлэлт шалгуурыг тавьдаг, хөндлөнгийн нөлөөлөлд автагдахгүй, илүү тэсвэртэй гэж тодорхойлогддог.

Гэхдээ, тусгай хүчнүүдийн алба хаагчид холбогдсон хэд хэдэн тохиолдлууд байдаг бөгөөд барууны улс орнуудтай хамааралтай. Цэргийн тусгай хүчин болон хууль сахиулах албаны SWAT нэгжүүдэд ажиллаж байсан, ажиллаж буй алба хаагчид экстремист үйл ажиллагаанд оролцсон, экстремист үзэл хандлагыг хөгжүүлэх, эсвэл хүчийг хэтрүүлэн хэрэглэх, дэвэргэх үзэгдэл гарах болсон. Энэ бүхэн нь экстремизм, радикалчлалын шинжийг агуулсан төдийгүй гэмт хэрэгт холбогдоход хүргэдэг. Улмаар дайны гэмт хэрэг үйлдсэн тохиолдлууд ч гарсан. Жишээлбэл, 1993 оны гуравдугаар сард Канадын агаарын десантын элит хүчинд харьяалагддаг хоёр цэргийн алба хаагч холбогдсон. Энхийг сахиулах ажиллагааны үеэр баривчлагдан хоригдож байсан 16 настай Сомали хүүг тохуурхах, зүй бус харьцаж зовоосны улмаас амь насаа алдсан. Улмаар, энэ үйлдэл нь дөрвөн сомали иргэний амь насыг хөнөөх үйл явдлын эхлэл болсон. Уг асуудалтай холбоотойгоор тус улсын парламентаас мөрдөн шалгах, хяналт шалгалтууд хийгдсэн. Шалгалтаар Канадын агаарын хүчний алба хаагчид болон барууны орнуудын экстремист бүлэглэлүүдийн хоорондын холбоо харилцаа илэрсэн. Тухайлбал, нэг цэргийн алба хаагч нь арьсны өнгө, үндэс угсаагаар ялгаварлах расист “Ку Клукс Клан” бүлгийн гишүүн байсан. Мөн агаарын цэргийн зарим алба хаагчид цагаан арьст үндсэрхэг үзлийг дэмжигчдийн бэлэг тэмдгийг байнга зүүдэг, Канад улсын үндсэрхэг үзэлтнүүдийн бүлэг болох нео-нацист “Heritage Front” бүлэглэлд сургалт явуулсан зэрэг үйлдлүүд тогтоогдсон. Үүний улмаас Канадын агаарын десантын ангийг татан буулгасан.⁷

Вьетнамын дайн дууссаны дараа АНУ-д тусгай ажиллагааны хүчний хуучин алба хаагчид экстремист барууны үзлийн хөрс суурийг бүрдүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлсэн. Тухайлбал, тусгай хүчний ахмад ажилтан Стив Миллер (Steve Miller) нь Каролина Ку Клукс Клан (KKK) байгууллагын номлогч болсон.⁸ 1982-1983 оны хооронд экстремист баруун үзэлтнүүдэд зориулан өөрийн тусгай ажиллагааны хүчний сургалтын хэв маяг, шаардлага шалгуурыг тусгасан сургалтын төвийг байгуулсан.⁹

1980 оны үед Каролина Ку Клукс Клан (ККК) нь экстремист үзлийн "Patriot Party" буюу цагаан арьстны үндсэрхэг нам болж өөрчлөгдсөн. 1979 оноос, зэвсэгт хүчинд 20 жил, "Ногоон малгайтнууд" (Green Berets) тусгай хүчинд 13 жил алба хаасан, Вьетнамд 2 удаа үүрэг гүйцэтгэж явсан, тэргүүн ахлагч Фрейзер Гленн Миллер (Frazier Glenn Miller)-ээр удирдуулах болсон. 2014 онд Гленн Миллер нь анти-семитик (anti-semitic) үзлийн улмаас гурван хүний амь насыг хөнөөсөн. Шүүхээс түүнийг гэм буруутайд тооцож цаазаар авах ял оногдуулсан. 2021 оны 5 дугаар сард уг шийдвэрийг гүйцэтгэсэн.¹⁰

Өөр нэг жишээ, "Ногоон малгайтнууд" тусгай хүчний бэлтгэл хурандаа, арьсны өнгөөр ялгаварлах, цагаан арьстны үзлийг дэмжигч Жеймс Гриц (Бо) юм. 1992 онд АНУ-ын Айдахо мужийн Рүби Ридж (Ruby Ridge) гэх газарт АНУ-ын холбооны ажилтнууд болон Ранди Вивер, түүний гэр бүлийн гишүүдийн хооронд зэвсэгт мөргөлдөөн болсон. Учир нь, хурандаа Жеймс Гриц (Бо) нь зэвсэгт мөргөлдөөний тэргүүн Рэнди Виверийн удирдлага дор ажиллаж байжээ. Тухайн үед эрх баригчид түүнийг, хэлэлцээр хийлгэх зорилгоор дуудсан байна.¹¹

Түүнчлэн, Олон улсын терроризмын эсрэг ажиллагааны хүрээнд Афганистан, Ирак дахь урт хугацааны цэргийн ажиллагаануудад, дайны гэмт хэрэг үйлдсэн тохиолдлууд гарсан. Тухайлбал, АНУ-ын Тэнгисийн цэргийн "SEAL" болон Австрали улсын тусгай хүчний зарим алба хаагчид холбогдсон. Тэд олзлогдсон зэвсэггүй, дайны олзлогдогсод (Prisoner of War)-ыг цаазлах, хүчийг хэтрүүлэн хэрэглэх, мөн амь үрэгдсэн хүний цогцсыг гутаан доромжлох зэрэг үйлдлүүдийг гаргасан.¹² 2001 оны есдүгээр сарын 11-ний террорист халдлагын дараагаар, тусгай хүчний алба хаагчдын хэрэгцээ шаардлага ихээр нэмэгдсэн нь алба хаагчдыг элсүүлэх, сонгох шалгуур үзүүлэлт сулрахад хүргэсэн.¹³ Жишээлбэл, Мэтт Бушбахер (Matt Buschbacher) нь 2002 оны наймдугаар сард, Тэнгисийн цэргийн SEAL багт ажиллаж байх үедээ нео-нацист "National Alliance" байгууллагын удирдагчдын хуралд оролцсон. Бушбахер, 1998 оноос хэт барууны экстремист бүлгүүдтэй урт хугацааны турш холбоо харилцаатай байсан гэдэг нь тогтоогдсон. Мэтт Бушбахер нь 2001 оны 10 дугаар сард Коронадо дахь SEAL хүчний сургалтыг дүүргэж, хожим Иракийн Багдад хотод байрлан үүрэг гүйцэтгэж байжээ.¹⁴

"Qanon"¹ болон вакцины эсрэг үзэл санаа, хүчирхийлэл, экстремист, хуйвалдааны хөдөлгөөнүүд дэлхий даяар түгээн дэлгэрэхийн хэрээр татан буугдсан болон идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй тусгай хүчнүүдийн алба хаагч, ахмад гишүүд нь дээрх үзэл санааг ил далд хэлбэрээр дэмжиж байгаа нь анхаарал татаж, ажиглагчдын санаа зовоох болсон.¹⁵ Үүний зэрэгцээ, 2020-2021 оны хооронд Герман Улсад элит цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын доторх экстремизм радикалчлалын үзэл санаа, олон нийтэд дуулиан тарьсан тохиолдлууд гарсан. Германы цэргийн (Bundeswehr) тусгай хүчний салбар нэгж "Kommando Spezialkräfte (KSK)"-ийн нэгэн офицерын бичсэн нийтлэлд зарим салаанд экстремизм, радикалчлалын үзэл газар авч байгааг анхааруулсан байжээ. Уг мэдээлэл нийтэд ил болсны дараа, 2020 оны долоодугаар сард Германы Батлан хамгаалах яам харьяа салбар нэгжээ татан буулгасан.¹⁶

Мөн Германы тусгай бэлтгэлтэй мэргэшсэн тактикийн нэгжүүд дотор экстремизм, радикалчлал үзэлтэй холбоотой тохиолдлууд гарсан байна. 2019 оны 11 дүгээр сард Мекленбург-Баруун Померани мужийн S.W.A.T-тай чиг үүргийн хувьд ижил үйл ажиллагаа явуулдаг "SEK" тусгай хүчний албан хаагчид хэт барууны экстремист үзэлтэй байсан бөгөөд зарим гишүүд нь террорист халдлага төлөвлөсөн, зохион байгуулахад оролцсон байж

¹ QAnon нь АНУ-д үүссэн хуйвалдааны онолын хөдөлгөөн бөгөөд 2017 онд "Q" нэртэй үл мэдэгдэх хүнээс интернетэд нийтлэгдсэн мэдэгдлүүдээс үүсэлтэй. Энэ хөдөлгөөн нь АНУ-ын засгийн газрын өндөр албан тушаалтнууд болон дэлхийн элитүүд хүчирхийлэл, хулгай, хуйвалдаанд оролцдог гэсэн үндэслэлгүй онолыг түгээдэг. QAnon-ы дагагчид ихэвчлэн Трампыг тэдний эсрэг тэмцэж буй баатар гэж үздэг бөгөөд олон нийтийн хэвлэл мэдээлэл, төрийн байгууллагуудад үл итгэх хандлагатай байдаг.

болзошгүй бүлэглэлтэй холбоо хамааралтай байсан нь олон нийтэд ил болсон.¹⁷ Улмаар “SEK” тусгай хүчний зарим хэсгийг татан буулгаж, удирдлагуудыг бүрэн сольж шинэчилсэн. Түүнчлэн, үүссэн асуудлын цар хүрээг тодорхойлох, судалгаа хийх, дүгнэлт гаргах ажлын хэсгүүд байгуулагдсан.¹⁸

Улмаар 2021 оны 6 дугаар сард Франкфурт дахь SEK-ийн салбар нэгжийг татан буулгаж, түүний 18 алба хаагч экстремизм радикалчлал бүлгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон болох нь тогтоосон тул үүрэгт ажлаас нь чөлөөлсөн.¹⁹ Цэрэг, хууль сахиулах байгууллагын алба хаагчдын экстремист радикалчлалын үзэл санаа, үйл ажиллагаа нь олон нийтэд аюул учруулж, албадын үйл ажиллагааны чадавхыг сулруулах эрсдэлтэй.²⁰ Жишээлбэл, экстремистүүд нь нарийн мэргэжил эзэмшсэн мэргэжилтнүүд байж болох бөгөөд мэргэн буудагчийн чадвар, тэсрэх бодис ашиглах, хүнд зэвсэг хэрэглэх, мөрдөн шалгах нууц ажиллагааны эсрэг ажиллагаа явуулах, тактик болон бусад төрлийн тулалдах арга ухаанд мэргэшсэн экстремистүүд болж аюул учруулж болзошгүй юм.

Эдгээр жишээг харгалзан үзвэл цэрэг, цагдаагийн тусгай хүчин, тактикийн нэгжүүдийн ямар онцлог шинж чанарууд нь экстремизм, радикалчлал үзэлд автах, өртөхөд нөлөөлж болзошгүйг онолын хувьд судлах, үндсэн асуултын хариултуудыг олохыг зорьсон.

Энэхүү сэдэв нь цэрэг, цагдаагийн тусгай хүчнүүд, S.W.A.T багийн алба хаагчдыг бусад төрөл мэргэжлийн алба хаагчидтай харьцуулахад экстремизм радикалчлал үзэлд илүү өртөмтгий гэж шууд ойлгож болохгүй гэдгийг онцлон хэлэх ёстой. Учир нь, харьцуулалт хийхэд шаардлагатай мэдээлэл дутмаг, хоорондын ялгаа заагийг харуулсан бодит судалгаа, бүрэн мэдээлэл байхгүй байна. Зөвхөн Герман улсад гарсан тохиолдлыг авч үзсэн бөгөөд Герман Улсын цэргийн тагнуулын байгууллага (Militärischer Abschirmdienst-MAD) нь экстремизм, радикалчлал үзлийн эсрэг ажлыг хариуцдаг.²¹ Тус албанаас гарсан мэдээллийг харахад Германы тусгай хүчний командлал (KSK)-ын харьяа нэгжүүдэд эзлэх хувь нь өндөр байгааг харуулсан. Сэдвийн хүрээнд цэргийн тусгай ажиллагааны хүчин болон хууль сахиулах албаны S.W.A.T нэгжүүд нь өөр салбар нэгжүүдээс онцлог ялгаатай байдал, өртөгдөх шалтгаан нөхцөлийг тогтоох, автагдаж болох гол хүчин зүйлийг агуулж болзошгүй гэдгийг авч үзсэн. Гэхдээ, эдгээр нэгжүүдийн нууцлагдсан, хаалттай байдлын улмаас экстремизм радикалчлал тархалтын шалтгаан нөхцөлийг урьдчилан тодорхойлох боломжийг олгохгүй байгаа нь учир дутагдалтай. Цэрэг, цагдаагийн тусгай хүчин, S.W.A.T багууд нь бусад салбар нэгжүүдтэй харьцуулахад өртөгдөх эрсдэлтэй хүчин зүйлсийг агуулж болохыг үгүйсгэхгүй. Эдгээр нэгжүүдийн алба хаагчид хамгийн өндөр сахилга бат, үүрэг хариуцлага, мэргэжлийн ур чадвар болон өндөр ёс суртахуунтайгаар үйл ажиллагаа явуулдаг. Тэдний үйл ажиллагааны чадамж, мэргэжлийн ур чадвар нь сөрөг зүйлсээс болж сулрахыг анхааруулж байгаа нь гутаах, албаны нэр хүндэд халдах, ялгаварлах хандлага биш юм. Эрсдэлтэй хүчин зүйлсийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлснээр сөрөг зүйлсэд өртөгдөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулах боломжтой болно. Үүний зорилго нь цэргийн болон хууль сахиулах байгууллагуудыг гадаад орчны сөрөг нөлөөнөөс хамгаалах, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

Энэ нь экстремизм радикалчлалын үйлдэл, ёс суртахууны зөрчил, тэр дундаа зургаан тусгай болон элит хүчний алба хаагчдын дайны үед үйлдсэн гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа, ажлын хэсгээс гаргасан тайлангууд, цэрэг, цагдаагийн салбарт экстремизм радикалчлалын талаар хийгдсэн зарим нэг судалгааны материалуудыг ашиглан судалгааны асуултыг тавьсан. Ингэхдээ Герман, Канад, Австрали, АНУ зэрэг улс орнуудын тайлан, эх сурвалжуудад тулгуурласан. Үүнээс гадна, нээлттэй эх сурвалж болон академик мэдээллийн сангуудаас хайлт хийсэн. Одоогоор Герман, Канад, Австрали, АНУ зэрэг улс орнууд мөрдөн шалгах ажиллагааны тайланг нийтэд ил болгосон. Эдгээр улс орнууд зохиогчийн мэдлэгт

тулгуурлан академик мэдээллийн санд судалгааны зорилгоор тайлангууд оруулсан. Тайлангуудын дөрөвт нь цэрэг, цагдаагийн тусгай хүчин, S.W.A.T нэгжүүдийн алба хаагч нартай холбоотой бөгөөд экстремизм радикалчлалын үзэл санааг агуулсан. Тухайлбал, Герман, Канадын тайлангуудад дурдагдсан. Австрали, АНУ-ын оруулсан нэмэлт тайланд илүү өргөн цар хүрээг авч үзсэн бөгөөд ёс суртахууны хүчин зүйл, хэт туйлширсан үйлдэл, дайны үеийн гэмт хэргүүд хамаарна. Цэрэг, цагдаагийн тусгай ажиллагааны хүчний алба хаагчдын ёс суртахууны зөрчил дутагдал, радикалчлал, дайны гэмт хэргүүдтэй холбоотой бодит мэдээлэл хаалттай хязгаарлагдмал учраас Австрали, АНУ-ын нэмэлт тайлан нь илүү дэлгэрэнгүй ойлголтуудыг олж авахад чухал ач холбогдолтой.

Судалгааны хүрээнд өртөгдөж болзошгүй хүчин зүйлсийн талаар ерөнхий байдлаар авч үзсэн бөгөөд баталгаажуулахгүй. Гэсэн хэдий ч, аль болох дэлгэрэнгүй тодруулахыг хүссэн зүйлс нь цэрэг, цагдаагийн тусгай хүчний (SOF,SWAT) алба хаагчдын экстремизм радикалчлал, ёс суртахууны зөрчил дутагдлуудыг мөрдөн шалгах ажиллагааны тайлангуудаас олж авсан дүгнэлт, мэдээлэлд үндэслэгдсэн. Материалуудыг судлах явцад нийтлэг гурван асуудалд таамаглал дэвшүүлсэн. Үүнд:

1. Цэргийн болон хууль сахиулах байгууллагуудад төрөл мэргэжлийн салбарууд, газар хэлтэс, тасаг, салаа, бүлэг гэх мэтчилэн нэгжүүд хэрэгжүүлэх чиг үүргээс хамааран өөр өөрийн онцлог, уур амьсгал, хэв маяг, үнэт зүйл бүхий төрөлжсөн жижиг нэгжүүд оршин байдаг.²² Эдгээр жижиг нэгжүүд нь хэт туйлширсан үзэлд автах, элсэгдэх нь харилцан адилгүйгээр бөгөөд эрсдэлд өртөх магадлалтай. Энэ нь тухайн орчны соёл, алба хаагчдын уур амьсгал, гүйцэтгэх үүргийн онцлог, байгууллагын бүтэц зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг.

Энэ бүхнийг тодруулахад туршлага багатай, алба хаагчдын халаа сэлгээ ихтэй, орлого цалин багатай, эмзэглэж явдаг хүчин зүйлс, шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор экстремизм радикал нөлөөлөлд өртөгдөх магадлал өндөртэй. Гэхдээ хор уршиг, учирч болзошгүй эрсдэл талаасаа, тулалдах болон байлдааны өндөр туршлагатай, хоорондоо нягт холбоо харилцаатай тусгай ажиллагааны нэгжүүд нь өөр хоорондоо ялгаатай. Тухайлбал, байлдааны туршлага, дайны болон ажиллагааны тухайн нөхцөл байдлаас үүдэлтэй сэтгэцийн эрүүл мэндийн асуудлууд гэх мэт.²³ Хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул учруулсан тулалдаан, хүчирхийлэл, осол гэмтэл зэрэг хүнд нөхцөл байдлын дараа үүсэж болох стресс болон сэтгэцийн эмгэг (PTSD)-үүд нь хүчтэй, хавсарсан байдлаар радикалчлалд өртөхөд нөлөөлөх хүчин зүйл болно.²⁴

2. Экстремист үзэл бодол, үйлдэл хоорондын харилцаа нарийн төвөгтэй, шугаман бус шинжтэй.²⁵ Гэсэн хэдий ч, цэрэг, хууль сахиулах байгууллагууд дунд экстремист үзэл санааг агуулсан, төстэй үзэл бодолтой алба хаагчид түгээмэл бөгөөд хууль бус, хууль зөрчсөн үйлдэл хийхгүй байж болно. Гэхдээ, эдгээр байгууллагуудын үйл ажиллагааны чадамжид хор уршиг учруулж болзошгүй. Учир нь ийм хандлага нь олон нийтийн, хамт олны итгэл үнэмшлийг бууруулж шударга бус хандах, төвийг сахих, мэргэжлийн ур чадвар, албаны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх, цаашлаад ардчилсан тогтолцоо бүхий улс орнуудын засаглалын үндсийг сулруулж болзошгүй юм.

3. Сэдэвт дурдагдсан Герман, Канад, Австрали, АНУ зэрэг улс орнуудын цэрэг, цагдаагийн тусгай ажиллагааны нэгжүүдийг харьцуулан авч үзэхдээ улс төр, хууль эрх зүй болон тогтолцооны хувьд ижил төстэй суурь зарчмуудад тулгуурласан. Тухайлбал, ижил төстэй бүтэц, иргэдийн сонгох сонгогдох эрх чөлөө, хүний эрхийг хамгаалах, хуулийн засаглалд тулгуурласан нийгэм зэргийг харгалзсан.

Түүнчлэн, Австрали нь НАТО-гийн гишүүн бус боловч хамтын ажиллагааны түвшинд хөтөлбөр хэрэгжүүлдэг. Бусад нь НАТО-ийн гишүүн орнууд юм. Эдгээр улс орнуудын цэргийн

боловсрол, сургалт, тактик, стратеги, үзэл баримтлалын хувьд төстэй цэргийн стандартуудыг баримталдаг. Мөн тагнуул болон хууль сахиулах байгууллагууд нь уялдаа холбоо сайтай, хамтарсан бодлого хэрэгжүүлдэг, мэдээлэл, сургалт, мэргэжлийн ур чадвараа хуваалцдаг. Жишээлбэл, "Есөн нүд" (Nine Eyes) хамтын ажиллагаа нь эдгээр орнуудын аюулгүй байдлыг хамгаалах, террорист ажиллагааг илрүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох гэх мэт. Эдгээр орнууд үндэсний онцлог ялгаануудтай хэдий ч, цаашид илүү дэлгэрэнгүй тодорхой судалгаануудыг ирээдүйд хийх шаардлагатай.

Барууны хэт туйлшрал (экстремизм)

Барууны туйлшрал “extreme right” гэх ойлголт нь хэт туйлшрал, радикалчлалыг судалдаг мэргэжилтэн, доктор Миллер-Идрисс (Cynthia Miller-Idriss, 2018) тодорхойлолтод үндэслэсэн.²⁶ Энэ нь "хар арьстны эсрэг үзэл (xenophobic); ардчиллын эсрэг; эрх мэдэлд хэт төвлөрөх, засгийн газар, цагаачлалын эсрэг (anti-immigrant); еврейн эсрэг (anti-semitic); фашист, гомофоб (homophobic) буюу гомосексуал хүмүүсийг эсэргүүцэх, үзэн ядах; угсаатны үндсэрхэг үзэл (ethnonationalist); арьс өнгөөр ялгаварлан гадуурхах (racist); зэрэг үзэл санаа, үйлдэл, холимог байдал, зорилго бүхий бүлгүүд болон улс төрийн намуудыг илэрхийлнэ" гэж тайлбарласан. Мөн неонацист (neo-nazi) буюу нацист үзэл санааг дахин сэргээх, цагаан арьстнуудыг бусад арьстнуудаас илүүд үзэх үзэл (white power), арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, хүйс, сөрөг бэлгийн чиг хандлагыг үзэн ядах, дайсагнал, хүчирхийллийг сурталчилж, хэрэгжүүлдэг нийгмийн бүлгүүд (hate groups) зэргийг ойлгоно.

Барууны хэт туйлшрал “extreme right” нь нэгэн төрлийн нэгдмэл хөдөлгөөн биш. Харин хүчирхийлэл, хүний тэгш бус байдлыг дэмжих үзэл санааны эргэн тойронд давхацсан бүлгүүд, түүний хуваагдмал хэв маяг, үзэл санааны сүлжээ юм. Иймд цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчид барууны хэт туйлшрал, экстремизмд татагдах үйл явцыг илүү нарийвчлан үзэхийн тулд дараах хоёр хүчин зүйлсийг ялгаж үзэх шаардлагатай. Үүнд:

а) Барууны хэт туйлшрал, экстремист үйл ажиллагаа явуулдаг бүлэглэлүүдтэй харилцаа холбоотой байх, эсвэл тэдний гишүүнчлэлд орох явдал юм. Энэ нь тухайн бүлгүүд өөрсдийгөө хүлээн зөвшөөрүүлэх, мөн хууль сахиулах болон тагнуулын байгууллагуудтай гинжин хэлхээнд орох, тэднийг зохион байгуулалттай дэвэргэх үзэгдэл юм;

б) Цагдаа, цэргийн алба хаагчдын дунд барууны хэт туйлшрал, экстремист үзэл санааны гол цөмийг бүрдүүлэх хандлагатай. Жишээлбэл, (арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл; неонацизм; еврейчүүдийг үй олноор хөнөөсөн түүхэн эмгэнэлт явдлыг гуйвуулан магтах, зөвтгөх үзэл (shoah); цагаан арьстныг дээдлэх үзэл;) гэх мэт. Мөн энэ бүхэнтэй нягт холбоо хамааралтай байх (жишээ нь, эрчүүдийг үргэлж хүчирхэг, түрэмгий байх, эрсдэлд дурладаг, сул дорой байдлаас эмээх, эмэгтэйлэг болон даруу зан чанарыг сул дорой гэж үзэх, буруутгах (toxic masculinity); мөн антисемитизм буюу еврейчүүдийг гадуурхах үзэл санаа, хандлагуудыг хууль сахиулах болон цэргийн алба хаагчид дэмжих; зэргийг ойлгоно. Эдгээр нь зарим тохиолдолд хамтрах, эсвэл тус тусдаа байдлаар илрэх боломжтой.

Тусгай ажиллагааны хүчин (зэвсэгт хүчин)

"Тусгай ажиллагааны хүчин" гэсэн нэр томьёо нь мэргэжилтнүүдийн дунд багагүй маргааныг дагуулдаг.²⁷ Жишээлбэл, НАТО тусгай ажиллагаа гэдгийг “онцгой үүрэг даалгавар гүйцэтгэхээр томилогдсон, тодорхой бүтэц, зохион байгуулалттай, сургаж бэлтгэгдсэн, тусгай зориулалтын зэвсэг, техник, хэрэгслээр хангагдсан хүчнүүд гүйцэтгэдэг цэргийн үйл ажиллагаа юм. Эдгээр нь өндөр шалгуур бүхий мэргэжлийн алба хаагчдаас бүрдсэн, уламжлалт бус арга тактик, дэвшилтэт техник, бүтээлч шийдлүүдийг ашигладаг, онцгой нөхцөл байдалд оновчтой арга барилаар үйл ажиллагаа явуулдаг” гэж тодорхойлдог.²⁸

Чиг үүрэг нь мэдээлэл цуглуулах зорилготой нууц ажиллагаа; тодорхой нутаг дэвсгэр, барилга байгууламж, стратегийн ач холбогдол бүхий байршлыг хяналтад авах, эзлэх; аливаа байгууламж, зэвсэг техник, дэд бүтцийн үйл ажиллагааг тасалдуулах, бүрэн устгах; ач холбогдол, эрх мэдэл бүхий хүн, албан тушаалтан, удирдагч, бусад этгээдийг олзлох, баривчлах; барьцаалагдсан хүнийг аврах, алдагдсан тоног төхөөрөмж, чухал мэдээллийг буцаан авах; аливаа халдлагыг таслан зогсоох, дайралт хийх, довтлох чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг.²⁹ Тусгай хүчний мэргэжилтэн, адмирал Эрик Т.Олсон (Eric T. Olson, USA) үзэж байгаагаар эдгээр ажиллагаанууд нь голчлон давуу нөхцөл байдлыг бий болгож, бага хүчээр томоохон үр дүнд хүрэх (asymmetric advantage) илүүрхэх, давуу талуудыг олж авах зорилготойгоор хэрэгждэг.³⁰

Израйлын судлаач Шамир (Shamir), Бен-Арии (Ben-Ari) нар нь тухайн ажиллагааг хэрэгжүүлэхээр үүрэг хүлээсэн алба хаагчдын гурван гол шинж чанарыг тодорхойлсон. Үүнд:

1. Эсрэг талын бүсэд нэвтрэн орж, үр дүнтэй ажиллагааг явуулдаг жижиг багууд нь мэргэжлийн өндөр чадвартай бөгөөд төвөгтэй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд дэвшилтэд шинэлэг шийдлүүдийг олоход чиглэгддэг.

2. Тусгай шалгуурыг хангасан, сонгогдож бэлтгэгдсэн, мэргэжлийн өндөр түвшний сургалтад хамрагдсан алба хаагчид байдаг.³¹ Товчоор хэлбэл, тусгай ажиллагааны хүчний алба хаагчдын гол шинж чанарууд нь олон талт үүрэг гүйцэтгэх чадвар, янз бүрийн нөхцөлд түргэн дасан зохицох, байнгын бэлэн байдлыг хангах, онцгой нөхцөлд бүтээлчээр ажиллах, тулгарч болзошгүй аюул, сорилтуудад оновчтой шийдвэр гарган даван туулах чадвар юм. Эдгээр нь өндөр эрсдэлтэй, урт хугацааны ачаалал, стрессийн нөхцөлд амжилттай ажиллахад зайлшгүй шаардлагатай. Мэдээж, энэхүү хариуцлагатай үүрэг даалгавар болон өндөр шаардлагууд нь бие бялдар, сэтгэл зүйн хувьд тэсвэртэй, хамгийн өндөр түвшинд бэлтгэгдсэн алба хаагчдыг шаарддаг. Анхан шатны элсэлт, шалгаруулалт, үе шаттай сургалтууд нь хатуу хяналттай, өрсөлдөөн ихтэй байдаг.³²

Энэ бүхний гол агуулгаас харахад, сэтгэл зүйн тэсвэр тэвчээрээс гадна дасан зохицох чадвар, асуудлыг оновчтой шийдвэрлэх, эргэцүүлэн түргэн сэтгэх чадварууд нь тусгай ажиллагааны хүчинд элсэх, сонгон шалгаруулалтад голлох шинж чанарууд болдог бөгөөд дараагийн сургалтуудад илүү бүтээлч байдлаар хөгжүүлэгддэг.³³ Түүнчлэн, эдгээр нь экстремист бүлэгт элсэх, радикалчлалд өртөхөөс хамгаалах хүчин зүйлс болдог.

Тусгай бэлтгэлтэй, тактикийн мэргэшсэн баг (SWAT) (Хууль сахиулах алба)

Ихэнх тохиолдолд, хууль сахиулах албаны тусгай бэлтгэлтэй, тактикийн мэргэшсэн багуудыг Хойд Америкийн "“Special Weapons and Tactics”" (S.W.A.T) багуудтай жишиж үздэг. АНУ-ын Үндэсний Тактикийн Алба Хаагчдын Холбоо (National Tactical Officers Association) тодорхойлсноор “Онцгой нөхцөл байдлын үед мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий мэргэшсэн хууль сахиулах баг юм. Тус нэгжид ажиллах алба хаагчдыг элсүүлж, сонгон шалгаруулж, бэлтгэж, техник, тусгай хэрэгслээр тоноглож, олон нийтэд хор уршиг, аюул учруулах өндөр эрсдэлтэй, онцгой нөхцөл байдлын үед мэргэжлийн туслалцаа үзүүлэх, үүссэн асуудлыг шийдвэрлэхэд зориулан бэлтгэдэг. Энэ нь хууль сахиулах бусад нэгжээс өөрийн гэсэн онцлог ялгаатай. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах, болон бусад нэгжүүд чиг үүргээ хэрэгжүүлэх явцад чадвар дутсан, тусгай бэлтгэлтэй нэмэлт хүч, шаардагдах үед дэмжлэг үзүүлдэг.”³⁴

Мөн хууль сахиулах байгууллагын тусгай бэлтгэлтэй, мэргэшсэн багийн алба хаагчдын дунд, мэргэжлийн болон үүрэг даалгаврын ялгаатай байдал гардаг. Мөн байгууллагын бүтэц болон ажиллагааны шинж чанаруудын хувьд олон янз байдаг. Үндэсний Тактикийн Алба Хаагчдын Холбооны үзсэнээр, нэгдүгээр түвшин (tier 1)-ний тактикийн нэгжүүд нь ямар ч

онцгой нөхцөл байдлын үед мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд бэлэн байх, өндөр чадвар, чадамжтай байхыг шаарддаг бөгөөд дараах нөхцөл байдалд дэмжлэг үзүүлэхийг шаарддаг. Тухайлбал, Барьцаанд авагдсан хүнийг чөлөөлөх; галт зэвсэг хэрэглэсэн, зэвсэглэсэн этгээдийн үйлдлийг таслан зогсоох, баривчлах; мэргэн буудагчийн ажиллагаа; хор уршиг учруулж болзошгүй эрсдэлтэй нөхцөлд шүүхийн тогтоолыг хэрэгжүүлэх, нэгжлэг болон хойшлуулшгүй ажиллагаанд оролцох; эсэргүүцэл үзүүлж болзошгүй сэжигтнийг саатуулах, хуяглан хүргэх; эрсдэл өндөртэй иргэн, албан тушаалтныг хамгаалалтад авах, өндөр түвшний хамгаалалтад ажиллах; террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох; эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр тусгай үүрэг даалгавар гүйцэтгэх; алба хаагчид гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх гэх мэт.³⁵

Иймээс, “SWAT” багийг бусад тусгай ажиллагааны хүчнүүдтэй адилтгаж үздэг. Хууль сахиулах байгууллагын тусгай хүчний алба хаагчид, өндөр эрсдэлтэй нөхцөл байдалд үүрэг гүйцэтгэдэг нь өөрсдийн болон хамтрагч нарынхаа амь нас, эрүүл мэндэд төдийгүй ажиллагааны үеэр алдаа гарах, цаашлаад олон нийтэд аюул учруулах эрсдэлтэй байдаг. Иймээс, эдгээр алба хаагчид галт зэвсэг, тусгай тоног төхөөрөмж (сумнаас хамгаалах бамбай, хаалга, эд зүйл эвдэгч багаж г.м) ашиглах эрхтэй тул өндөр ур чадвартай байхаас гадна бие бялдар, сэтгэлзүйн хувьд өндөр түвшний бэлтгэлтэй байдаг. Эдгээр шаардлага нь алба хаагчдаас хариуцлагатай байхыг шаарддаг. Учир нь “SWAT” багийн алба хаагчид онцгой нөхцөлд дэвшилтэт техник хэрэгсэл, тактикийн ур чадвараа ашиглах шаардлагатай байдаг нь тэднийг хамгийн аюултай үүрэг гүйцэтгэхэд дуудагддаг гол шалтгаан юм. Ерөнхийдөө цэргийн болон цагдаагийн дотоод шинж чанарууд ихээхэн ялгаатай.³⁶

Гэвч, цэргийн тусгай ажиллагааны хүчин, цагдаагийн “SWAT” багийн зарим чиг үүрэг, даалгавар, ажиллагааны цар хүрээ, тодорхойлолтууд нь давхацдаг. Ялангуяа терроризмтой тэмцэх болон барьцаалагчдыг чөлөөлөх ажиллагаанаас харагддаг. Хоёр байгууллагын хувьд алба хаагчдыг элсүүлэх, бэлтгэхэд бие бялдын болон сэтгэл зүйн хамгийн өндөр шалгуур үзүүлэлтийг шаарддаг. Амь насанд аюултай, эрсдэл өндөртэй нөхцөлд албадлага болон хүч хэрэглэж, ямар ч нөхцөл байдлын үед үйл ажиллагаа явуулах өндөр чадвартай. Мөн төрөл бүрийн галт зэвсэг, тоног төхөөрөмжийг эзэмших, хэрэглэх эрхтэй байдаг. Түүнчлэн, энэхүү хоёр байгууллагын тусгай хүчний орчин нөхцөл нь элит дайчин, бүтээлч, уян хатан байдлыг сайн хөгжүүлдэг (тайлбар хэсэгт үзнэ үү) Зарим тохиолдолд цэргийн тусгай хүчнүүд, SEAL багууд нь Ирак, Афганистанд гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зэрэг цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд ашиглагддаг.³⁷ Мөн АНУ-ын цагдаагийн байгууллагын “SWAT” нэгжүүд нь цэргийн тактик, туршлага, арга барилуудыг үйл ажиллагаандаа ашиглахыг зорьдог.³⁸ Түүнчлэн, цэргийн тусгай ажиллагааны хүчин болон SWAT нэгжүүдийн дотор янз бүрийн хандлага, санаа бодол байж болохыг үгүйсгэхгүй. Хууль сахиулах болон цэргийн чиг үүрэг, үйл ажиллагааны ялгаа, давхцалыг ярих хэрэгтэй.

Энэхүү сэдвийн гол асуудал нь экстремизм, радикалчлалд өртөж болзошгүй талаар анхааруулах, салбар нэгж тус бүрийн онцлог байдлыг ойлгох, хувьсан өөрчлөгдөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх явдал юм.

Дүгнэлт, санал

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын тусгай ажиллагааны хүчний (SOF, SWAT) экстремизм, радикалчлалд өртөмтгий байдал нь салбар, нэгж тус бүрийн үйл ажиллагааны онцлог, арга барилыг гүнзгий ойлгох нь радикалчлалд өртөх эрсдэлтэй хүчин зүйлсийг зөв тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга замыг боловсруулахад зайлшгүй шаардлагатай байна. Энэхүү асуудлын хүрээнд судалгаа нь радикалчлал болон экстремизмтэй холбоотой үр дагаврыг судлах шаардлагатай гэдгийг саяхнаас хүлээн зөвшөөрч

эхэлсэн. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын тусгай бэлтгэлтэй, мэргэшсэн тактикийн SOF, S.W.A.T нэгжүүдтэй холбоотой асуудлууд нь ихэвчлэн бие бялдар, сэтгэл зүйн тусгай шалгуур үзүүлэлтүүд, сонгон шалгаруулалт, сургалтын үйл явц, ажиллагааны гүйцэтгэл, чиг үүрэг зэрэгт төвлөрч ирсэн. Харин эдгээрээс бусад талаарх судалгаа ховор байна. Тиймээс, ирээдүйн судалгааг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын SOF, S.W.A.T нэгжүүдийн үзэл баримтлал, алба хаагчид албаны болон албанаас гадуурх орчин нөхцөлд, тусгай бүлгүүдийн доторх нэгдмэл байдлыг бүрдүүлж байдаг хүчин зүйлс, мөн улс төрийн болон үзэл санааны талаарх сэтгэлгээ хандлагууд, ёс зүй, ёс суртахууны тал бүрийн нөлөөллүүдийг хувь хүн, хамтын түвшинд хэрхэн илрэхийг нарийвчлан судлах шаардлагатай. Одоогийн мөрдөн шалгах ажиллагааны тайлан, ажлын хэсгүүдээс гаргасан дүгнэлтүүд (Таблиц 1-д үзүүлсэн) нь тал бүрийн хүчин зүйлс, дотоод болон гадаад нөлөөллийн шинж чанар, хэлбэрүүдийг бүрэн судлах шаардлагатайг харуулж байгаа төдийгүй, бодитой дүгнэлт гаргахад шаардлагатай баримтуудыг ил болгосон.

Иймд, энэхүү сэдэв нь тусгай бэлтгэлтэй нэгжүүдийн экстремизм, радикалчлалд өртөх, нөлөөлж болзошгүй хүчин зүйлсийг судлах чиглэлд эхлэлийг тавьж байна. Энэ судалгаанд онолын хувьд нарийвчлан тодруулсан болон нөлөөлөх хүчин зүйлс нь хамгийн тэргүүнд тодруулах шаардлагатай, анхаарал татсан хүчин зүйлүүд юм. Тухайлбал, тусгай хүчин, тусгай ажиллагааны нэгжүүдийн үйл ажиллагаа, бүтэц, нууц, хаалттай байдал зэргийг судалдаг Нидерланд улсын судлаач Кромповетс (Crompvoets) авч үзэхдээ "цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын SOF, S.W.A.T нэгжүүдтэй холбоотой нууцлал нь зайлшгүй авч үзэх шаардлагатай чухал хүчин зүйл" болохыг дурдсан.¹²⁷ Албаны нууц тээгч буюу бодит үнэн байдлыг мэддэг, тухайн ажиллагаанд оролцогчид нь бусдаас илүү, ялгаатай, тусгай гэдгийг мэдрүүлэхэд хүргэж, зарим тохиолдолд албан ёсны улс төрийн шийдвэр гаргалт болон олон нийтэд хийсэн мэдэгдлүүдтэй зөрчилдөхөд хүргэж болзошгүйг анхаарах хэрэгтэй. Мөн судлагдаагүй өөр нэг хүчин зүйл нь цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын тусгай ажиллагааны хүчнүүд (SOF, S.W.A.T) дотор, тэдгээрийн орон зайд үхэл болон хүчирхийллийг хэрхэн авч үздэг, ямар байр сууринаас ханддаг гэдгийг судлах шаардлагатай байж магадгүй.

Цэрэг, цагдаагийн алба хаагчид амь насаа алдах эрсдэл нь мэргэжлийн онцлогтой холбоотой байдаг. Элит болон тусгай нэгжүүдийн хувьд өөрсдийгөө дээд зэргийн тулаанчид хэмээн үзэж, зорилгодоо заавал хүрнэ гэсэн үзэл санаа, ёс суртахуун болон үзэл баримтлал нь нөлөөлж болзошгүй. Товчоор хэлбэл, эдгээр орчны дотоод хүчин зүйлсийг илүү гүнзгий судалж, эмзэг шинж чанар, цар хүрээг илүү бүрэн мэдэх шаардлагатай. Мөн цэргийн болон хууль сахиулах тусгай ажиллагааны хүчнүүд (SOF, S.W.A.T)-ийн алба хаагчид нийгмийн бусад бүлгүүдтэй харилцах харилцааг илүү нарийн судлах хэрэгтэй. Тусгай хүчний дотоод үзэл баримтлал нь бусад цэрэг, цагдаагийн орчинтой харьцуулахад экстремизм, радикалчлалын нөлөөнд илүү хялбар өртөж болох эсэхийг цаашид судлах нь зүйтэй. Түүнчлэн, экстремизм, радикалчлал болон тусгай хүчний нэгжүүд нь нийгмийн ижил тэгш байдлын талаарх үзэл зарчмуудад сөргөөр хандаж, өөрсдийгөө тусгай, онцгой гэж үзэх ойлголттой холбоотойгоор гол нөлөө үзүүлж болох бөгөөд цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын тусгай ажиллагааны (SOF, S.W.A.T) нэгжүүд рүү чиглэсэн шилжилтийн зам, холбооснуудыг үүсгэж болзошгүй. Гэсэн хэдий ч, иймэрхүү "гүүр" байдлаар шилжилт хийх нь нэг замаар чиглэгдэж явагддаггүй гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Экстремизм, радикалчлалын бүлгүүд болон оролцогчид элит цэргийн болон цагдаагийн алба хаагчдыг өөртөө татах, элсүүлэх хүсэл сонирхолтой байгааг тодорхойлоход хялбар байдаг ч, харин тэдгээр бүлгүүдийн хувьд ийм шилжилт хийх шалтгаан нөхцөл нь төдийлөн тодорхой бус юм. Ирээдүй рүү чиглэсэн судалгаанд цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын тусгай ажиллагааны (SOF, S.W.A.T) нэгжүүдийн алба хаагчдын экстремизм, радикалчлалд оролцогч хувь хүний дотоод

сэтгэл, хүсэл сонирхол, хэрэгцээ, зорилго зэрэг мотивацийн хүчин зүйлсийг судлах шаардлагатай.

Мөрдөн шалгах ажиллагааны тайлангууд болон энэхүү судалгааны үндсэн дээр (Таблица 1 үзэх) тусгай ажиллагааны (SOF, S.W.A.T. нэгжүүдийн дотор экстремизм, радикалчлалын эсрэг арга хэмжээ авах, тэдний тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх нь шаардлагатай. Тухайлбал, цөөнх үндэс угсаа болон хүйсийн төлөөллийг нэмэгдүүлэх арга хэмжээг боловсрол, сургалттай хослуулан хэрэгжүүлэх боломжтой. Энэ нь үндэс угсаа, хүйс, арьсны өнгө гэх мэт биологийн хувьд давамгайлах үзлийг эсэргүүцэх хандлагыг дэмжих, үзэл баримтлал бий болгох зорилгоор хэрэгжүүлэх ёстой. Жишээлбэл, эмэгтэйчүүдийн тусгай ажиллагаанд оруулсан хувь нэмрийг түүхийн болон орчин үеийн жишээнүүдэд тулгуурлан таниулах замаар уг зорилгыг биелүүлэх боломжтой.¹²⁸

Цаашлаад, цэргийн болон хууль сахиулах тусгай ажиллагааны (SOF, S.W.A.T.) тал бүрийн сургалтуудад ёс зүй, ёс суртахууны боловсролыг өргөнөөр цогц, уялдаа холбоотой байдлаар оруулах хэрэгтэй. Ёс зүй, ёс суртахуунтай холбоотой асуудлыг зөвхөн албан тушаал дэвших, бусад зүйлд ахиц дэвшилд гаргахад нь шалгуур үзүүлэлт болгож үзэх биш, уялдаатай цогц байдлаар зайлшгүй авч үздэг болгох ёстой. Үүнийг хэрэгжүүлбэл чухал ач холбогдолтой ажил болж чадна.¹²⁹

Мөн үүрэг гүйцэтгэлээс гадна, гадаад сөрөг хүчин зүйл буюу хор уршигт хүргэж болзошгүй нөлөөллүүдийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх нь чухал. Экстремизм, радикалчлал болон түүний зохиомол онол, бүлгүүдийн нөлөө нь албаны үйл ажиллагаа, бэлэн байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг ойлгуулах, түүнчлэн экстремизм, радикалчлалыг таних шинж тэмдэг, бэлгэдэл, анхааруулга тэмдэглэгээний талаарх бодит мэдлэгийг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага бий болсон. Мөн салбар нэгжүүдийн онцлог, баримтлах зарчмуудыг харгалзан мэдээлэл өгөх зохих бүтэц, удирдлага, сүлжээг бий болгох шаардлагатай.

Эцэст нь, өндөр ёс суртахуунд тулгуурласан, хаалттай, хязгаарлагдмал байдлын хамааралгүйгээр нэгдмэл, мэргэшсэн, нягт зохион байгуулалт, өөрийгөө болон хамт олноо, албаны эрх ашгаа хамгаалах, хоорондын итгэлцэл, хүндэтгэл, хариуцлага зэргийг эрхэмлэсэн зарчмууд нь экстремизм, радикалчлалын эсрэг тэсвэртэй байдлыг бий болгоход хамгийн чухал суурь хүчин зүйл болж чадна.

Ашигласан материал

1. Michael A. Jensen, Elizabeth Yates, and Sheehan Kane, *Radicalization in the Ranks: An Assessment of the Scope and Nature of Criminal Extremism in the United States Military* (Maryland, MD: National Consortium for the Study of Terrorism and Responses to Terrorism (START), 2022), 2.
2. Sophia Moskalenko, "Zip-Tie Guys: Military-Grade Radicalization among Capitol Hill Insurrectionists," *Dynamics of Asymmetric Conflict* 14, no. 2 (2021)
3. Daniel Koehler, "A Threat from Within? Exploring the Link between the Extreme Right and the Military," *ICCT Policy Brief*, no. September 2019 (2019): 5-6.
4. Kathleen Belew, *Bring the War Home: The White Power Movement and Paramilitary America* (Cambridge, Massachusetts: Harvard University Press, 2018), 144.
5. Belew, *Bring the War Home: The White Power Movement and Paramilitary America*, 198.
6. David Philipps, *Alpha: Eddie Gallagher and the War for the Soul of the Navy Seals*, First edition. ed. (New York: Crown, 2021); Paul Le Gay Brereton, *The Inspector-General of the Australian Defence Force Afghanistan Inquiry Report* (Canberra, Australia: Commonwealth of Australia, 2020).

7. Matt Kennard, *Irregular Army: How the Us Military Recruited Neo-Nazis, Gang Members, and Criminals to Fight the War on Terror* (London and New York: Verso Books, 2012).
8. David Holthouse, "Several High Profile Racist Extremists Serve in the U.S. Military," SPLC Intelligence Report Summer Issue (2006).
9. Carol E. Lee, "In Secret Facebook Groups, America's Best Warriors Share Racist Jabs, Lies About 2020, Even Qanon Theories," NBC News, April 16 2021; Kelly Weill, "What Happens When Ex Navy Seals Go Full Qanon?," The Daily Beast, September 1 2020.
10. Deutsche-Welle, "Ksk: German Special Forces Company Dissolved Due to Far-Right Concerns," Deutsche Welle, July 30 2020.
11. Zeit-Online, "Lorenz Caffier Tauscht Lka-Führung Nach Prepperaffäre Aus," Die Zeit, November 26 2019.
12. DPA, "Rechtsextreme Umtrieben Im Sek: Dienstzeit Wird Begrenzt," Süddeutsche Zeitung, August 12 2020. New York Times, June 10 2021. (2021).
13. Christopher F. Schuetze, "Elite German Police Unit Disbanded over Far-Right Group Chat," The New York Times, June 10 2021.
14. Håvard Haugstvedt and Daniel Koehler, "Armed and Explosive? An Explorative Statistical Analysis of Extremist Radicalization Cases with Military Background," *Terrorism and Political Violence*
15. Matthias Gebauer, "Militärgeheimdienst Ermittelt Gegen Eliteeinheit Ksk," Der Spiegel, September 9 2019.
16. Joseph Soeters, "Organizational Cultures in the Military," in *Handbook of the Sociology of the Military*, ed. Giuseppe Caforio and Marina Nuciari (Cham: Springer International Publishing, 2018).
17. Haugstvedt and Koehler, "Armed and Explosive? An Explorative Statistical Analysis of Extremist Radicalization Cases with Military Background."; Jensen, Yates, and Kane, *Radicalization in the 25 Ranks: An Assessment of the Scope and Nature of Criminal Extremism in the United States Military*.
18. Kira Harris, Eyal Gringart, and Deirdre Drake, *Military Retirement: Reflections from Former Members of Special Operations Forces*, vol. 10 (Directorate of Future Land Warfare, 2013).
19. Harris Chaiklin, "Attitudes, Behavior, and Social Practice," *The Journal of Sociology & Social Welfare* 38, no. 1 (2011).
20. NATO, "Nato Glossary of Terms and Definitions (English and French). Aap-06 (Edition 2015)," (Brussels: NATO Standardization Agency: 2-S-8, 2015), 118.
21. Shamir and Ben-Ari, "The Rise of Special Operations Forces: Generalized Specialization, Boundary
22. Susan S White et al., "Developing Adaptive Proficiency in Special Forces Officers," (Fort Bragg: U.S. Army Research Institute for the Behavioral and Social Sciences, 2005).
23. Scott A Beal, "The Roles of Perseverance, Cognitive Ability, and Physical Fitness in Us Army Special Forces Assessment and Selection," (Fort Bragg: U.S. Army Research Institute for the Behavioral and Social Sciences, 2010).
24. NTOA, *Tactical Response and Operations Standard for Law Enforcement Agencies* (Colorado Springs: National Tactical Officers Association (NTOA), 2018), 12.
25. Sherene Razack, *Dark Threats and White Knights: The Somalia Affair, Peacekeeping, and the New Imperialism* (Toronto: University of Toronto Press, 2004). 27
26. Original in German, Roland Eckert, Johannes Jungbauer, and Helmut Willems, "Polizei Und Fremde. Belastungssituationen Und Die Genese Von Feindbildern Und Übergriffen," in *29 Wiederkehr Des "Volksgeistes"? Ethnizität, Konflikt Und Bewältigung*, ed. Roland Eckert (Opladen: Leske und Budrich, 1998), 224.

27. Nora Rebekka Krott, Eberhard Krott, and Ines Zeitner, "Xenophobic Attitudes in German Police Officers: A Longitudinal Investigation from Professional Education to Practice," *International journal of police science & management* 20, no. 3 (2018).
28. Vida B. Johnson, "Kkk in the Pd: White Supremacist Police and What to Do About It," *Lewis & Clark Law Review* 23, no. 1 (2019): 205.
29. Jasmine R Silver et al., "Traditional Police Culture, Use of Force, and Procedural Justice: Investigating Individual, Organizational, and Contextual Factors," *Justice Quarterly* 34, no. 7 (2017). 68 Ibid., 17. 69 Ibid., 18.
30. Donna Winslow, *The Canadian Airborne Regiment in Somalia. A Socio-Cultural Inquiry.* (Ottawa, Canada: Minister of Public Works and Government Services Canada, 1997);
31. Samuel P Huntington, *The Soldier and the State: The Theory and Politics of Civil–Military Relations* (Cambridge, MA: Harvard University Press, 1981), 91-92.
32. See Amy Ross Arguedas et al., *Echo Chambers, Filter Bubbles, and Polarisation: A Literature Review* (Oxford: Reuters Institute University of Oxford, 2022), 10.
33. N. F. Johnson et al., "Hidden Resilience and Adaptive Dynamics of the Global Online Hate Ecology," *Nature* (2019); Savvas Zannettou et al., "What Is Gab: A Bastion of Free Speech or an Alt-Right Echo Chamber" (paper presented at the Companion Proceedings of the The Web Conference 2018, 2018).
34. Harris, Gringart, and Drake, *Military Retirement: Reflections from Former Members of Special Operations Forces*, 10.
35. Mohammad Atari et al., "Morally Homogeneous Networks and Radicalism," *Social Psychological and Personality Science* (2022).
36. Harris, Gringart, and Drake, "Leaving Ideological Groups Behind: A Model of Disengagement."
37. Maren Tomforde, "Combat Soldiers and Their Experiences of Violence: Returning to Post-Heroic Societies?," in *Handbook of the Sociology of the Military*, ed. Giuseppe Caforio and Marina Nuciari (Cham: Springer International Publishing, 2018).